



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 41 болон 42 дэх долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 10-р сарын 02-оос 10-р сарын 16-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 25 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Олон Улсын Валютын Сангаас дэлхийн эдийн засаг 2020 онд 4.4 хувиар агших шинэчилсэн төсөөллийг 10-р сарын 15-ны “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайландаа зарлалаа.** Энэ нь өмнөх улирлын төсөөллөөс 0.5 нэгж хувиар сайжирсан төсөөлөл бөгөөд үүнд 5, 6-р сард дэлхий даяар хөл хорио алгуур суларч 2-р улиралд эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр байсан, 3-р улиралд зарим салбарт сэргэлт ажиглагдсантай холбоотой байна. Харин 2021 онд дэлхийн эдийн засаг 5.2 хувийн өсөлттэй байгаа нь өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар бага байна. Суурь төсөөллийг тойрсон тодорхой бус байдлууд өндөр хэвээр байна. 2021 оноос хойш дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд буюу 2025 он хүртэл 3.5 орчим хувь болж аажмаар буурах төлөвтэй байхаар тооцсон байна.

Цар тахлын улмаас Дэлхийн ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн бодлого дор 1990-ээд оноос хойш аажмаар ахиц дэвшил гаргаад байсан улс орнуудын амьжиргааны дундаж түвшин буурах төлөвтэй байгааг онцоллоо. Мөн хямралын дарамт хөгжлийн түвшнээс хамааран харилцан адилгүй буюу буурай хөгжилтэй


орнуудад илүү хүнд туссанаар хамгийн багадаа 100 сая хүн нэн ядуусын эгнээнд шилжихээр байна. Ялангуяа мэргэжлийн ур чадвар доогуур залуус, эмэгтэйчүүдэд, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд илүү хүнд тусна гэжээ. Ингэснээр орлого багатай бүлгийн орлого улам буурч, орлогын тэгш бус байдал нэмэгдэхээр байна. Түүнчлэн цар тахлын үеэр сургуулиудыг хааснаар хүмүүн капиталын хуримтлал ноцтой буурч болзошгүй шинэ сорилт тулгарч байна. Мөн цар тахал намжсаны дараа улс орнуудын өрийн дарамт их хэмжээгээр нэмэгдэхээр байгааг онцоллоо.

- ОУВС-аас Монгол Улсын эдийн засгийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 1 нэгж хувиар муутгаж энэ онд 2 хувиар агшина гэж тооцоолжээ. Харин 2021 онд 6 хувиар сэргэж, 2025 он гэхэд 4.5 хувьд тогтворжино гэж дүгнэжээ. Инфляцын төсөөллийг энэ онд 4.5 хувь, ирэх онд 6.6 хувьд байна гэж тооцоолсон байна.
- **Roubini Global Economics** байгууллагаас дэлхийн эдийн засаг 2020 онд 4.2 хувиар агших шинэчилсэн төсөөллийг 9-р сарын 18-нд зарлалаа. Энэ нь 6-р сард хийсэн төсөөллөөс 0.2 нэгж хувиар буурсан төсөөлөл юм. Суурь төсөөлөлд өвлийн

улиралд цар тахлын тархалт дахин дэгдэж, хэсэгчилсэн хөл хорио тогтоосноор эдийн засгийн өсөлт оны 2-р хагаст савалгаатай байх, ирэх жилийн зун вакцин гарах, төсөв, мөнгөний бодлогууд эдийн засгийг дэмжихээр таамаглажээ. Суурь төсөөлөлд 2020 онд Хятадын эдийн засаг 2.1 хувиар өсөх, Евро бүс 8.5 хувиар агших, АНУ-ын эдийн засаг 4.5 хувиар агших, Оросын эдийн засаг 3.0 хувиар агшихаар тус тус үзсэн байна. Харин гутранги хувилбарт зарим орнууд хөл хориог хэт эрт цуцалснаар КОВИД-19-ийн дэгдэлт дахин нэмэгдэж, W хэлбэрийн хямрал ажиглагдах, дэлхийн эдийн засаг 2020 онд 5.0-8.0 хувиар агшин, 2022 оноос алгуур сэргэхэд хүрч болзошгүй гэж үзэж байна.

- Дэлхийн банкнаас “Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн төлөвийн тайлан”-г 2020 оны 10-р сард нийтэллээ. Уг тайланд **бүсийн эдийн засаг энэ онд 0.9 хувиар, үүнд Хятадын эдийн засаг 2.0 хувиар өсөхөөр** төсөөлжээ. Хятадын эдийн засгийн өсөлтөд Засгийн газрын зарцуулалт болон экспорт эерэгээр нөлөөлөх бол хэрэглээний сэргэлт алгуур байгаа нь сөргөөр нөлөөлнө гэж үзжээ. Ирэх онд Хятадын өсөлт 7.9 хувиар, бүс нутгийн бусад эдийн засгийн өсөлт 5 хувиар сэргэхээр төсөөлж байна. **Монголын** эдийн засгийн хувьд уул уурхай, үйлчилгээний салбар агшсанаар **эдийн засаг энэ онд 2.4 хувиар агших**, ирэх 2 жилд хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдэн 5 хувиар өсөх төсөөлөлтэй гэж Дэлхийн банкнаас төсөөлж байна. КОВИД-19 цар тахлын улмаас энэ онд ядуурлын түвшин сүүлийн 20 жилд анх удаа нэмэгдэж, 38 сая хүн ядуурлын дундаж түвшнээс доогуур орохоор байна.
- Oxford Economics байгууллагын 2020 оны 9/10-р сарын эдийн засгийн төсөөллөөр **дэлхийн эдийн засаг 4.4 хувиар агшиж, ирэх онд 5.4 хувиар**

өсөхөөр байна (Зураг 1). Сүүлийн саруудын тоон үзүүлэлтүүд эерэг гарч байгаа тул дэлхийн ДНБ 2-р улиралд огцом агшсан хандлага 3-р улиралд эргэж, сэргэлт бий болох хандлагатай байна. Гэсэн ч цар тахлын өмнөх 2019 оны сүүлийн улирлын ДНБ-ий түвшинтэй харьцуулахад 3-р улирлын ДНБ 4 гаруй хувиар доогуур байгаа нь дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үеэр ч ажиглагдаагүй том уналт юм.



Зураг 1. Oxford economics байгууллагын дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, 2020 оны 9-р сарын байдлаар

- Mckinsey&Co байгууллагын 9-р сарын эдийн засгийн нөхцөл байдлын түүвэр судалгаагаар ирэх 9 сард дэлхийн эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт өмнөх улирлын түүвэр судалгаанаас **сайжирсан байна**. Хэдийгээр эдийн засгийн нөхцөл байдал 6 сарын өмнөх үеэс муу байгаа хэдий ч 6-р сарын хүлээлттэй харьцуулахад 9-р сард дэлхийн томоохон корпорациудын захирлууд ирэх 6 сард эрэлт, ашиг нэмэгдэж, эдийн засгийн төлөв сайжрах хүлээлт 3 дахин нэмэгдсэн байна.
- **Олон Улсын Валютын Сангаас “Дэлхийн Санхүүгийн Тогтвортой байдлын тайлан”-г 10-р сарын 13-нд нийтэллээ.** Тус тайланд улс орнууд бодлогын шуурхай арга хэмжээ авснаар богино хугацаанд санхүүгийн тогтвортой байдлын эрсдэлээс сэргийлсэн, дэлхийн банкны системийн



хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай, эрсдэл бага байгаа ч зарим банкууд сөрөг шокын үед эх үүсвэрийн дутагдалд орж болзошгүй, хөрөнгийн зах зээл дээрх том ААН-үүдийн тэнцэл харьцангуй эрүүл, харин жижиг, дунд ААН-үүдийн эмзэг байдал нэмэгдсэн гэж дүгнэжээ. Түүнчлэн, зарим эрчимтэй хөгжиж буй орнууд өрийн дарамт, санхүүгийн тогтворгүй байдлын улмаас санхүүжилтийн хүндрэлд орж эхлээд байгаа бөгөөд цаашид эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд мөнгөний бодлого болон санхүүгийн нөхцөлийг зөөлрүүлэх замаар зээлийн өсөлтийг дэмжих нь чухал байгааг онцолжээ.

- **Олон Улсын Валютын Сангаас жилд 2 удаа эрхлэн гаргадаг дэлхийн улс орнуудын “Төсвийн Арга Хэмжээ” тайланг 10 дугаар сарын 14-нд нийтгэллээ.** Тус тайланд бичсэнээр КОВИД-19 цар тахал болон түүнтэй холбоотой хөл хорионоос үүдэн 9-р сарын 11-ний байдлаар энэ онд нийт 11.7 их наяд ам.доллар буюу дэлхийн нийт ДНБ-ий 12 хувьтай тэнцэхүйц төсвийн багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тус төсвийн тал хувь нь татварын хөнгөлөлттэй холбоотой нэмэлт зардалд, тал хувь нь төсвийн байгууллагын зээл, баталгаа, хөрөнгө оруулалт зэрэг хөрөнгийн хөрвөх чадварыг дэмжих арга хэмжээнүүдэд зарцуулагджээ. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн энэхүү шийдэмгий төсвийн арга хэмжээнүүдийн ачаар ард иргэдийн амь нас эрсдэх, эмзэг бүлгийн ард иргэдийн амьжиргааны түвшин, ААН-ийн болон эдийн засгийн үйл ажиллагаа улам дордох зэрэг эрсдэлээс сэргийлж чадсан гэж үзэж байна. Гэсэн хэдий ч улс орнуудын орлогын алдагдал их хэмжээгээр тэлж, санхүүгийн хямралын эрсдэл өндөр хэвээр байна. 2020 онд төсвийн алдагдал дунджаар ДНБ-ий 9 хувьд хүрэхээр байгаа бөгөөд дэлхийн нийт өрийн хэмжээ ДНБ-ий 100 хувьд


буюу түүхэн дээд хэмжээнд хүрэх төлөвтэй байна. ОУВС 2021 онд Хятад болон АНУ-аас бусад орнуудын эдийн засгийн идэвхжил сэргэж, хүүгийн түвшин болон улсын өрийн харьцаа тогтворжино гэсэн суурь төсөөлөлтэй байна. Үүний тулд ядуурал, ажилгүйдэл, амьжиргааны түвшний тэгш бус байдал зэргийг бууруулах, эдийн засгийг дэмжих тал дээр анхааран ажиллаж, шаардлагатай мөнгөний болон төсвийн бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж ОУВС-аас үзэж байна.

- 7-р сард бараг зогсонги байдалтай байсан **Европын жижиглэнгийн худалдаа 8-р сард хурдтай өслөө.** Бодит жижиглэнгийн худалдааны борлуулалт өмнөх жилийн мөн үеэс нэлээд өссөн нь Европын хэрэглээний салбар хүчтэй сэргэж байгааг илтгэж байна. Гэсэн хэдий ч цар тахлын дэгдэлт саяхан дахин нэмэгдсэн нь эдийн засагт хүндээр тусахаар байна. КОВИД-19-ийн дэгдэлтэд хамгийн ихээр өртсөн Испани улсын жижиглэнгийн худалдаа хямралын өмнөх түвшнээс хол доогуур хэвээр байна. Тодруулбал, Евро бүсийн жижиглэнгийн худалдаа 8-р сард өмнөх сараас 4.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар тус тус өссөн байна. Үүнд хувцаснаас бусад жижиглэнгийн худалдаа өссөн нь нөлөөллөө. Харин хувцасны худалдаа 8-р сард өмнөх сараас 7.7 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар буурсан нь хувцасны хэрэглээ буурсантай холбоотой. Харин онлайн жижиглэнгийн худалдаа 8-р сард өмнөх сараас 12.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өссөн дүнтэй байна. 8-р сард 50.5 байсан Евро бүсийн үйлчилгээний салбарын PMI индекс 9-р сард 48 болж буурсан нь 5-р сараас хойших хамгийн муу үзүүлэлт болсон бөгөөд Евро бүсэд эдийн засгийн идэвхжил буурсныг илтгэж байна.

- Европын Холбооны статистикийн газар болох Евростатын урьдчилсан тооцоогоор **Евро бүсийн жилийн инфляц 2020 оны 9-р сард өмнөх сараас 0.1 хувиар буурч -0.3% байх төлөвтэй** байна. Европын төв банк Евро бүсэд инфляц их хэмжээгээр буурч дефляцын дарамт тулгарч болзошгүй байгаад түгшиж байна. Еврогийн ханш ам.долларын эсрэг өсч байгаа нь импортын үнэ буурч, улмаар инфляц улам буурах дарамт болж байна. Инфляц бага байгаа нь бодит хүүгийн түвшинг нэмэгдүүлж, зээлийн зах зээлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.
- **Евро бүсийн** нэгдсэн PMI индекс энэ оны 8-р сард 51.9 байсан бол 9-р сард 50.1 болж аж үйлдвэрлэл бараг өсөлтгүй байв¹. Дэд бүлгээр задалж харвал боловсруулах салбарын PMI индекс энэ оны 8-р сард 51.7 байсан бол 9-р сард 53.7 болж өссөн хэдий ч үйлчилгээний салбарын PMI индекс 8-р сард 51.9 байсан бол 9-р сард 47.6 болж буурчээ. Испани, Францын зарим хэсгүүдэд вирусийн тархалт дахин дэгдэж, иргэдийн болгоомжлол нэмэгдсэн нь үйлчилгээний салбарын үйлдвэрлэл буурахад нөлөөлөв.
- IFO институцээс Евро бүсийн эдийн засгийн төлөв, байдлын тайланг 9-р сарын 29-нд нийтэллээ. Уг тайланд **Евро бүсийн эдийн засаг** оны эхний хагаст хүчтэй агшсан ч 3-р улиралд өмнөх улирлаас 15.2 хувиар, 4-р улиралд 1.4 хувиар тус тус нэмэгдэх төсөөлөлтэй буюу энэ онд бүсийн эдийн засаг нийт **8.0 хувиар агшихаар** байна (Зураг 2). Энэ оны 3-р улиралд эдийн засгийн сэргэлтийг боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт голлон бий болгохоор байна. Мөн хувийн хэрэглээ сэргэх хэдий ч гадаад эрэлт сул байж, хөрөнгө оруулалтын

тодорхой бус байдал үргэлжлэх тул бүсийн хөрөнгө оруулалт алгуур сэргэх төлөвтэй гэж үзжээ.

Seasonally and working day adjusted



Source: Eurostat and Ifo-Istat-KOF Forecasts

Зураг 2. Ifo институцийн Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

- **АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах хүчтэй байна.** АНУ-ын хуучин үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 7-р сард жилийн 2.4 хувиар өссөн бол 8-р сард жилийн 10.5 хувиар өсчээ. Түүнчлэн, шинэ үл хөдлөх хөрөнгийн (байшин, орон сууц) борлуулалт 8-р сард өмнөх оны мөн үеэс 43.2 хувиар өссөн нь урьд өмнө үзэгдээгүй өсөлт юм. Ийнхүү үл хөдлөх хөрөнгийн зах сэргэж байгаа нь санхүүжилтийн өртөг (хүү) бага байгаатай холбоотой. АНУ-ын боловсруулах салбарын PMI индекс энэ оны 8-р сард 52.7 байсан бол 9-р сард 53.7 болж өссөн, үйлчилгээний салбарын PMI индекс 8-р сард 55.0 байсан бол 9-р сард 54.6 болж өсөлт нь саарчээ. Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл өсч байгаа нь дотоод эрэлт болон ажил эрхлэлт нэмэгдэж байгаагийн илрэл гэж шинжээчид үзэж байна.
- Холбооны нөөцийн банкны тэргүүн Жером Пауэлл АНУ-ын эдийн засгийг сэргээхэд төсвийн дэмжлэг илүүдэхгүй, нэн даруй төсөв, мөнгөний хавсарсан бодлогоор хүчтэй дэмжлэг үзүүлэх хэрэгтэйг анхаарууллаа. Тэрээр “Төсвийн дэмжлэг дутвал эдийн

¹ IHS Markit-аас түүвэр судалгаанд суурилан тооцдог PMI индекс нь 50-аас дээш утга авбал тэлэлт, 50-с доош утгатай бол агшилтыг илтгэдэг.

засгийн сэргэлт удааширч, өрхүүдэд шаардлагагүй дарамт үүсгэнэ. Эсрэгээрээ дэмжлэгийг хэтрүүлэх эрсдэл нь одоохондоо бага байна. Цаг өнгөрөх тусам өрхийн худалдан авах чадвар муудаж, бизнесүүд дампуурч эдийн засгийн бүтээмж болон цалин буурна” гэж мэдэгдлээ.

Эх сурвалж:


1. Oxford economics, [World economic prospects](#)
2. SXCoal, [Chinese buyers look for more Mongolian coal amid reported import ban on Aussie suppliers](#)
3. JP Morgan, [Economic update](#)
4. Continuum Economics, [Global Outlook: A Vaccine for Growth](#)
5. Continuum Economics, [Global Outlook: A Vaccine for Growth](#)

6. Europa - EU, [Euro area annual inflation down to -0.3%](#)
7. Montsame, [Mongolia's economic growth to accelerate to over 5 percent in 2021-22. World Bank report finds](#)
8. World Bank, [East Asia and Pacific economic update October 2020](#)
9. Bloomberg, [What to Watch in China GDP Data as Economic Rebound Strengthens](#)
10. CNBC, [Fed chair Powell calls the U.S.economic recovery 'strong' but 'incomplete'](#)
11. IFO insitute, [Eurozone Economic Outlook: Eurozone GDP starts to recover](#)
12. IMF, [Global Financial Stability Report](#)
13. IMF, [World Economic Outlook October-2020](#)
14. Reuters, [Metals-Copper hits 1-week low as dollar rebounds, LME inventory rises](#)
15. Reuters, [Oil drops on higher inventors, weak U.S. stock markets](#)
16. Deloitte, [Global Economic Outlook](#)

2

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД


- Хятадын Үндэсний Статистикийн Хороо 10-р сарын 19-ний өдөр 3-р улирлын ДНБ-ий тоог зарлалаа. Блүүмбергийн эдийн засагчид өсөлтийг 5.3 хувь байхаар төсөөлж байсан бол гүйцэтгэлээр **Хятадын эдийн засаг 3-р улиралд ДНБ 4.9 хувиар өсчээ.** (Зураг 3)



Зураг 3. Хятадын эдийн засгийн төсөөлөл

Улмаар Хятадын эдийн засаг оны эхний 3 улиралд эдийн засаг нь нийт 0.7 хувиар өссөн байна. Экспортын өсөлт 4 дэх сардаа үргэлжлэн нэмэгдэж 9-р сард

жилийн 9.9 хувийн өсөлттэй байв. Хятадын аж үйлдвэрлэлийн PMI индекс 9-р сард хүлээлтээс давж 51.5 гарсан, аж үйлдвэрлэл 9-р сард энэ эрчээ хадгалсан тул аж үйлдвэрлэлийн өсөлт 3-р улиралд 5.6 хувьтай байхаар байна. Хөрөнгө оруулалт алгуур сэргэж, энэ онд 0.9 хувиар өсөх төлөвтэй байна. (Зураг 4)



Зураг 4. Хятадын улсын, хувийн сектор дахь хөрөнгө оруулалт

Хятадын ажилгүйдлийн түвшин цар тахлын дэгдэлтийн ид үе болох 2-р сард 6.2 хувь байсан бол 9-р сард 5.4 хувь

болж буурав. ОУВС-ийн төсөөллөөр Хятадын эдийн засаг энэ онд 1.9 хувиар, ирэх онд 8.2 хувиар өсөх төлөвтэй байна.

- **Жижиглэн худалдааны борлуулалт эдийн засгийн сэргэлтийг илтгэж байна.** Жижиглэн худалдаа оны эхний 7 сард агшсан бол 8-р сард жилийн 0.5 хувиар, 9-р сард 3.3 хувиар өсч сэргэлт бий болж байна. Хятадын Засгийн газраас зарим хөл хориог сулруулж, үзвэр үйлчилгээний зөвшөөрөгдөх хүний тоог нэмэгдүүлээд байгаа нь хэрэглээг дэмжиж, 9-р сард жижиглэн худалдааны өсөлтийг тэтгэв. Гэхдээ оны эхний 9 сараар авч үзвэл жижиглэн худалдааны борлуулалт 7.2 хувийн агшилттай байна. Онлайн худалдаа оны эхний 9 сард 15.3 хувиар өсч, жижиглэн худалдааны 24.3 хувийг бүрдүүлж байна. Мөн автомашины борлуулалт 9-р сард 7.4 хувиар өсчээ.
- **Үйлдвэрлэлийн үнийн индекс /ҮҮИ/** 7-р сард жилийн 2.4 хувиар буурсан бол 8-р сард 2 хувиар агшиж бууралт нь багасав. (Зураг 5)




Зураг 5. Хятадын аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл, ашиг, ҮҮИ

Салбараар нь авч үзвэл боловсруулах үйлдвэрлэлийн ашиг оны эхний 7 сард 4.5 хувиар буурсан бол эхний 8 сард 1 хувиар агшиж бууралт нь багасав. Компанийн төрлөөр авч үзвэл гадаадын хөрөнгө оруулалттай болон хувийн сектор дахь аж ахуйн нэгжүүдийн ашиг оны эхний 8 сард 0.4 хувь, 3.3 хувиар

тус тус буурав. Харин төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашиг оны эхний 7 сард жилийн 23.5 хувиар буурсан бол эхний 8 сард 17 хувиар агшиж, бууралт нь мөн багасав. Автомашин үйлдвэрлэгчид оны эхний 7 сард жилийн 5.9 хувийн алдагдалтай байсан бол эхний 8 сард жилийн 1.5 хувийн ашигтай ажилласан байна.

- **Хятадын коксжих нүүрсний эрэлт ойрын хугацаанд өндөр байхаар байна.** Хятадын коксжих үйлдвэрүүд өвлийн улирлын үйлдвэрлэлийн нөөц бэлтгэлээ базааж байгаа тул 10, 11-р саруудад коксжих нүүрсний эрэлт өмнөх саруудаас хүчтэй нэмэгдэхээр байна. Хятадын төрийн өмчит нүүрсний компаниудыг 10-р сарын 1-ээс Австралийн нүүрсний худалдан авалтаа зогсоох албан бус чиглэл өгсний дараагаас Хятадын баруун, хойд мужуудын үйлдвэрүүд Монголоос импортлох коксжих нүүрсний эрэлтээ нэмэгдүүлээд байна. Монгол Улс энэ оны 9-р сард Хятад улс руу 4.65 сая тонн нүүрс экспортолсон (оны эхний 9 сард 19.82 сая тоннд хүрсэн) нь өмнөх сараас 17.2 хувиар өссөн дүн юм. (Зураг 6) Гашуун сухайт боомтоор нэвтэрч буй ачааны машины тоо 9-р сард өдрийн 1000 байсан бол 10-р сарын дунд үед өдрийн 1200 болж нэмэгдлээ. Гэхдээ коксжих нүүрсний импортын энэ оны квот дуусах дөхөж байгаа болон Австралийн нүүрсэнд тавьсан хориг ойрын хугацаанд сулрахааргүй байгаа тул Хятадын нийт коксжих нүүрсний импорт энэ оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 3-4 сая тонноор бага байх төлөвтэй байна.



Зураг 6. Хятадын коксжих нүүрсний импорт

- **Хятадын нүүрсний дотоодын угаасан коксжих нүүрсний нийт үйлдвэрлэл** 8-р сард 42.3 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар нэмэгдсэн бол оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурав. Коксжих нүүрсний эрэлт 8-р сард 49.3 сая тонн хүрч жилийн 3.3 хувиар нэмэгджээ. Хятадын Шанси мужийн угаасан коксжих нүүрсний нийт үйлдвэрлэл 8-р сард 20.63 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс

4.4 хувиар нэмэгдсэн бол оны эхний 8 сард 142.8 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өсөв. Харин Шандонг, Гуаизоу, Хэнан мужуудын угаасан коксжих нүүрсний нийт үйлдвэрлэл оны эхний 8 сарын байдлаар 36.4 сая тонн, 21.2 сая тонн, 16.7 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 5.8 хувь, 27.1 хувь, 7.4 хувиар тус тус буурлаа. Зөвхөн 8-р сарыг авч үзвэл Шандонг, Гуйзоу, Хэнан мужийн үйлдвэрлэл 4.39 сая тонн, 1.89 сая тонн, 2.02 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 4.8 хувь, 38.5 хувь, 5.5 хувиар тус тус буурлаа.

Эх сурвалж:

1. China Insight: Recovery on, No waiting for Vaccine, Bloomberg
2. China Coal/Coke Market Monthly, Sep 2020, Sxcoal.com
3. China React: Industrial Profit Growth Strong, Signs of Cresting, Bloomberg
4. China Preview: PMIs to show recovery slowing, still has legs, Bloomberg

3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын 2021 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлуулахаар төсвийн төслийг хуулийн хугацаанд өргөн бариад байна. Өргөн барьсан төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2020 оны тодотголын түвшнээс 2.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж 11.8 их наяд төгрөгт, нийт зарлага 2020 оны тодотголоос 625.9 тэрбум төгрөгөөр буурч 13.9 их наяд төгрөгт хүрэх ба тэнцвэржүүлсэн тэнцэл 2.2 их наяд буюу ДНБ-ий 5.1 хувьд хүргэж төсвийн үзүүлэлтүүдийг сайжруулсан байна. Энэ удаагийн өргөн барьсан төсвийн төсөл нь халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх багц арга хэмжээг хэрэгжүүлснээр нэмэгдээд байгаа төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, цахим, ил тод, үр ашигтай төсвийн бодлого хэрэгжүүлэх, өрийг оновчтой удирдах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэжээ. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны төсвийн төсөлд дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлжэхээр төлөвлөн ажиллаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Үүнд:

Нэг. Бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих зорилгоор ирэх 2021

онд татварын хувь хэмжээг тогтвортой хадгалах, татварыг хялбаршуулах, технологийн дэвшил ашиглан бүртгэлийг сайжруулж хамрагдалтыг нэмэгдүүлэх, татварын үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлэх, татвараас зайлсхийх явдлыг бууруулан татварын тэгш шударга орчин бүрдүүлэх бодлого баримтлах, **Хоёр.** Эмнэлгийг биш үйлчлүүлэгч-иргэнийг дагасан, эм, тариа, эмчийн цалинд бус харин эмчлэн эдгээсэн хүний тоо, эмчилгээний чанарт суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангах, **Гурав.** Коронавируст халдварт цар тахлын улмаас үүссэн эрсдэлийг бууруулах зорилгоор иргэдийн орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих зарим арга хэмжээг үргэлжлүүлэх, **Дөрөв.** Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн үр дүнг ахиулах, **Тав.** Төрийн үйлчилгээг цахимжуулж, төсвийн зардлыг хэмнэх, **Зургаа.** Орон нутгийн төсвийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж зэрэг тулгамдсан асуудлаа орон нутагт бие даан шийдвэрлэх боломжийг олгож сум, дүүргийн **Долоо.** Цар тахлын улмаас улсын эдийн засаг нэлээд агшиж байгаа энэ үед мөчлөг сөрсөн бодлогын хүрээнд нийгэм, орон нутгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг зогсоохгүй үргэлжлүүлэх зэрэг бодлогын арга хэмжээнүүдийг төлөвлөн УИХ-д өргөн мэдүүлээд байна.

ЗГХЭГ-ийн дарга НҮБ-ын суурин зохицуулагч Тапан Мишраг төрөлжсөн салбарын төлөөлөгчдийн хамт хүлээн



авч уулзлаа. “КОВИД-19” цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй шат дараатай арга хэмжээнүүд үр дүнгээ өгч байгааг ноён Топан Мишра уулзалтын эхэнд онцлоод НҮБ-ын зүгээс энэ тал дээр тууштай дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж ирснийг тэмдэглэв. Цаашид эдийн засгийг сэргээх болон бусад чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, НҮБ-ын шинэчлэлийн үйл явц, “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”, “НҮБ-аас Монгол Улсад 2017-2021 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” баримт бичиг зэрэг асуудлаар харилцан мэдээлэл солилцож, ЗГХЭГ-тай ойрын үед хамтарч ажиллах боломжуудын талаар талууд санал солилцлоо. ЗГХЭГ-ын хувьд НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар болон төрөлжсөн байгууллагуудтай цаашид хоёр чиглэлд түлхүү хамтарч ажиллах хүсэлтэй байна гээд төрийн үйлчилгээг цахимжуулах “E-Mongolia”-ийн техникийн шилжилтийг хийхэд, мөн төрийн албыг чадавхжуулах тал дээр идэвхтэй хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа уламжлав. Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг үндэсний түвшинд хангахад шаардлагатай санхүүжилтийг цогцоор шийдвэрлэх зорилгоор Олон талт түншлэгчдийн платформыг байгуулах чиглэлээр хамтран ажиллахад талууд уулзалтын үеэр санал нэгдсэн байна.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч ноён

Павит Рамачандраныг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд ноён Павит Рамачандран Монгол Улсын эдийн засгийн ерөнхий төлөвтэй холбоотой шинэчилсэн тооцоо судалгааг

танилцуулж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн эдийн засгийн ирээдүйн төлөв, сорилтууд болон дунд хугацаанд хэрэгжих “Банкны шинэтгэлийн хөтөлбөр”-ийн үндсэн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчны шинэчлэлтийн талаар мэдээлэл өгөв. Мөн үеэр талууд Монгол Улс ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 2020 оны 5-р сард хэрэгжүүлж дууссан тухай болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас 2020 онд багтаан гарах ажил, үүрэг даалгаврын баталгаажуулалт болох газар дээрх хяналт шалгалтын үнэлгээ энэ сард амжилттай хийгдээд байгаа талаар ярилцлаа. Уулзалтын төгсгөлд АХБ-аас банк санхүүгийн системийг шинэчлэн бэхжүүлэх, банкны дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв.

Монголбанк 09 дүгээр сарын 25-ны өдөр УИХ-д өргөн барьсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төслөө 10-р сарын 9-ний өдөр олон нийтэд нээлттэй хэлэлцүүлээ. Төрөөс Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл нь ирэх онд Төв банкнаас дангаараа болон бусад төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлогын зорилтыг тодорхойлдог үндсэн баримт бичиг юм. Монголбанк Төв банкны нээлттэй ил тод байдлыг хангах, хариуцлагатай байдлыг хэрэгжүүлэх үүднээс уг хэлэлцүүлгийг мэргэжлийн хүрээлэл төдийгүй олон нийтэд танилцуулах зорилгоор 2017 оноос хойш 4 дэх жилдээ зохион байгуулж байна. Энэ жилийн хувьд уг хэлэлцүүлэгт төрийн болон



төрийн бус, олон улсын байгууллагын төлөөллүүдийг түлхүү оролцуулан мөнгөний бодлогын ирэх жилд дэвшүүлсэн зорилтуудын талаар илүү нарийвчилсан мэдээллийг өглөө. Мөн оролцогчдын санал бодлыг тусгах үүднээс хэлэлцүүлгийнхээ агуулгыг өргөжүүлж, үндсэн хоёр чиглэлд зохион байгуулсан нь өмнөх жилүүдийнхээс онцлог болж байна. Хэлэлцүүлгийн үндсэн илтгэлийг Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б. Баярдаваа танилцуулж, эдийн засгийн төлөв байдал, ирэх сорилтуудыг даван туулахад Төв банкнаас хэрэгжүүлэх бодлогын зорилтуудын талаар мэдээлэл өглөө. Хэлэлцүүлгийн удаах илтгэл Дэлхийн банкны эдийн засагч Б. Даваадалайн “Уул уурхай ба Урт хугацааны тогтвортой өсөлт” байв. Энэхүү илтгэлийг Дэлхийн банкнаас манай улсад хийсэн эдийн засгийн хөгжлийн загварын тойм судалгааны хүрээнд танилцуулсан юм. Арга хэмжээний хоёрдугаар хэсэг “Эдийн засгийн төлөв ба Мөнгөний бодлого”,

“Банк, санхүүгийн салбарын шинэчлэл ба зохицуулалтын орчин” сэдэвт хэлэлцүүлгээр үргэлжилсэн. Үүнд санхүүгийн нарийн мэргэжлийн судлаачид, Монголбанкны бодлогын газрын захирлууд оролцлоо. Тэд дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдэж оны эхний хагаст 9.7 хувиар буураад байгаа дотоодын эдийн засгийг тогтворжуулах, цаашид баримтлах бодлогын гол чиглэлүүд зэрэг сэдвээр дэлгэрэнгүй ярилцав. Тухайлбал “Зээлийн хүү бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах, банк санхүүгийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлэхэд холбогдох эрх зүйн зохистой орчныг бүрдүүлэх ажлуудыг төр, хувийн хэвшил хамтран үр дүнтэйгээр хийх шаардлага тулгарч буйг хөндлөө. Эдгээр асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зорилтууд ирэх оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөлд тусгагдаад байгаа юм.



4 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс **3.7%**, өмнөх оны мөн үеэс **6.8%**-аар сулраад байна /2020.10.15-ны байдлаар/.
- ТОП-20 индексийн үзүүлэлт **17,393** болж өмнөх оны мөн үеэс 8.5%-аар буураад байна /2020.10.15-ны байдлаар/.

14 ХОНОГИЙН МЭДЭЭ						
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны	Өөрчлөлт	Өсөлт
		/2020.10.15/	/2020.10.01/	/2019.10.15/	/2020.10.01- 2020.10.15/	/өмнөх оны мөн үе/
Валютын урсгал болон хани						
Ам.долларын ханш	₮	2,853.5	2,854.7	2,671.6	-1.2	6.8%
Хөрөнгийн зах						
ТОП-20 индекс		17,393.3	17,531.6	19,001.4	-138.3	-8.5%
МУ-ын бондуудын өгөөж						
Монгол 2021 - МАЗААЛАЙ	%	3.9	4.0	5.0	-0.1	-23.4%
Монгол 2022 - ЧИНГИС	%	3.8	4.0	5.0	-0.1	-22.9%
ХХБ САМУРАЙ	%	1.1	1.1	0.6	0.0	88.8%
Монгол 2024 - Хуралдай	%	4.4	4.9	5.5	-0.4	-19.9%
Монгол 2023 - Гэрэгэ	%	4.0	4.3	5.2	-0.3	-22.8%
МУХБ	%	5.1	5.6	6.0	-0.5	-15.6%
МИК	%	12.0	11.9	11.2	0.0	7.1%

Тайлбар: Хүснэгтэд 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаарх хамгийн сүүлийн үеийн тоон мэдээг тусгасан бөгөөд зарим тоон мэдээ нь яг тус өдрийнх биш байна.


Хөрөнгийн зах /2020.10.15/:

Зураг 7. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Зураг 8. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ СУУРЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 2020 оны 9 дүгээр сарын байдлаар **92.5%**-тай, нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө **83.8%**-тай биелсэн буюу төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 7.5%-иар, төсвийн зарлага төлөвлөснөөс 16.2%-иар бага байна.
- 2020 оны 9 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны эргэлт **9,075.2 сая ам.доллар** гарч, тэнцэл **1,219 сая ам.долларын ашигтай** гарлаа.
- Зөвхөн 9 дүгээр сард 668.2 сая ам.долларын экспорт, 474.9 сая ам.долларын импорт хийсэн байна.
- 2020 оны 9 дүгээр сарын инфляц улсын хэмжээнд **1.7%**, Улаанбаатар хотын хэмжээнд **1.4%** гарлаа.
- Зээл олголтын хэмжээ 8 дугаар сард 1.57 их наяд төгрөг байсан нь 9 дүгээр сард 1.8 их наяд төгрөг болж **14.6%**-аар, зээл төлөлт 1.51 их наяд төгрөгөөс 1.82 их наяд төгрөг болж **21%**-аар өссөн байна.


ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	САРЫН МЭДЭЭ			Өөрчлөлт /2020.08- 2020.09/	Өсөлт /өмнөх оны мөн үе/
		Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе		
		/2020.09/	/2020.08/	/2019.09/		
Монгол Улсын нэгдсэн төсөв						
Орлого						
<i>Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж</i>	тэрбум ₮	6,701.4	5,699.4	7,749.0	17.6%	-13.5%
<i>Татварын орлого</i>	тэрбум ₮	6,090.7	5,160.1	7,011.2	18.0%	-13.1%
<i>Татварын бус орлого</i>	тэрбум ₮	610.8	539.3	737.8	13.3%	-17.2%
Зарлага						
<i>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</i>	тэрбум ₮	9,440.7	8,356.0	7,264.4	13.0%	30.0%
<i>Урсгал зардал</i>	тэрбум ₮	7,497.0	6,590.4	5,783.5	13.8%	29.6%
<i>Хөрөнгийн зардал</i>	тэрбум ₮	1,930.3	1,756.1	1,320.3	9.9%	46.2%
<i>Цэвэр зээл</i>	тэрбум ₮	13.5	9.5	160.6	41.5%	-91.6%
Гадаад худалдаа						
Худалдааны эргэлт	сая \$	9,075.2	7,932.1	10,544.9	14.4%	-13.9%
Экспорт	сая \$	5,147.1	4,478.9	5,946.1	14.9%	-13.4%
Импорт	сая \$	3,928.1	3,453.2	4,598.8	13.8%	-14.6%
Худалдааны тэнцэл	сая \$	1,219.0	1,025.7	1,347.3	18.8%	-9.5%
Инфляц						
Жилийн инфляц /Улс/	%	1.7	2.1	9.0	-18.1%	-80.9%
Жилийн инфляц /УБ хот/	%	1.4	1.7	10.5	-19.4%	-86.9%
Банкны зээлийн тайлан						
Зээлийн хэмжээ						
<i>Олгосон зээл /тухайн сард/</i>	тэрбум ₮	1,801.8	1,571.6	1,442.2	14.6%	24.9%
<i>Төлөгдсөн зээл /тухайн сард/</i>	тэрбум ₮	1,821.1	1,505.3	1,551.5	21.0%	17.4%
<i>Зээлийн үлдэгдэл</i>	тэрбум ₮	17,087.6	17,097.6	17,188.5	-0.1%	-0.6%

*Гадаад худалдааны мэдээ нь 15 хоног бүр шинэчлэгдэж байна.



Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл /2020.09/:

Зураг 1. Татварын орлогын задаргаа, сараар



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Хүснэгт 1. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Татварын орлого	6,403,135.6	5,984,345.9	93.5%	(418,789.6)
Татварын бус орлого	726,751.3	610,767.1	84.0%	(115,984.3)
Нийт орлого ба тусламжийн дүн	7,129,886.9	6,595,113.0	92.5%	(534,773.9)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


Хүснэгт 2. Нийт зарлага ба цэвэр зээл

	Төсөв	Гүйцэтгэл	Хувь-1	Зөрүү
Урсгал зардал	8,438,568.3	7,496,950.8	88.8%	(941,617.5)
Хөрөнгийн зардал	2,735,663.7	1,930,307.1	70.6%	(805,356.5)
Цэвэр зээл	89,512.3	13,464.8	15.0%	(76,047.5)
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,263,744.3	9,440,722.7	83.8%	(1,823,021.5)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк


Гадаад худалдаа /2020.09/:

Зураг 2. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар


Зураг 3. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Банкуудын зээлийн тайлан /2020.09/:


Зураг 4. Зээлийн эргэн төлөлт, тэтгэврийн зээлийг хассан



Эх сурвалж: Монголбанк

Инфляц /2020.09/:

Зураг 5. Инфляц, сараар




Эх сурвалж: Монголбанк

5


МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/10/16	Өөрчлөлт				YoY	
		daily	weekly	monthly	year to date		
Зэс	6724	0.0%	-1.0%	-1.0%	9.0%	18.0%	Хятадын хаягдал зэсийн импорт буурах төлөв, ам.доллар чангарсан, нөөц буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс буурахад нөлөөлөв.
Коксжих нүүрс	129.0	-	-	-	-	-	Худалдааны маргаан, КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмэж буурах төлөв болон Хятадын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх төлөв, нөөц хадгалагдсан нөлөөгөөр үнэ бага түвшинд хадгалагдаж байна.
Төмрийн хүдэр	118.2	-1%	-4.0%	-5.0%	28.0%	32.0%	Хятадын гангийн үйлдвэрлэлийн идэвхжил үргэлжилж, эрэлт хадгалагдсаны зэрэгцээ цар тахлын улмаас Бразилын нийлүүлэлт хэвийн түвшинд хүрээгүй тул үнэ бага зэрэг буурав.
Алт	1899.3	0.0%	-2.0%	-3.0%	24.0%	27.0%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна.
Газрын тос (Брент)	42.9	-1%	0.0%	2.0%	-35.0%	-28.0%	КОВИД-19-ийн тархалт буурахгүй нэмэгдсээр буй нөлөөгөөр эрэлт буурах төлөв хадгалагдаж газрын тосны үнийн төлөв сул хэвээр байна. Ирэх оноос эрэлт сэргэхээр байгаа ч ОПЕС-ийн орнууд нийлүүлэлтээ нэмснээр үнэ одоогийн түвшнээс өсөхөөргүй байгаа аж.

Зураг 8. Дэлхийн зах зээл дээрх алт, төмрийн хүдрийн спот үнэ



Зураг 9. Дэлхийн зах зээл дээрх зэс, газрын тосны үнэ



Эх сурвалж: Блүүмберг